



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 07 сарын 22 өдөр

Дугаар 321

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын
худалдаагаар худалдах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1,2,3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 3, 4.2, 4.3 дахь заалт, “Мэдээ тайлангийн маягт батлах тухай” 269 дүгээр тогтоолын 2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Стандарт, хэмжил зүйн газрын харьяа Дархан-Уул аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ өртгөө нөхсөн нийт 37,170,000.00 (гучин долоон сая нэг зуун далан мянган) төгрөгийн балансын үнэ бүхий автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Стандарт, хэмжил зүйн газрын тамгын дарга Б.Эрдэнэзул, Дархан-Уул аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дарга И.Алтанцэцэг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1 Үндсэн хөрөнгийг дуудлагаар худалдах ажлын хэсэг томилж, холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2 Дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3 Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагын мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 4 дүгээр улиралд багтаан мэдээ тайлангийн баталсан маягтаар ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦӨТГЭГЧ

А.АРИУНБОЛД

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ
ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.ТҮВШИНЗАЯА

0000633

C:\2019.07.22 16г нуралдаан.docx



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 07 дугаар сарын 22-ны 32 дугаар тогтоолын хүрээнд

СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗРЫН ХАРЬЯА ДАРХАН-УУЛ АЙМГИЙН СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ХЭЛСТСҮЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭН НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

| Д/д | Автомашины марк, улсын дугаар, арал | Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он | Явсан км | Тоо ширхэг | Балансын үнэ (төгрөг) | Хуримтлагдсан элэгдэл (төгрөг) | Үлдэгдэл өртөг (төгрөг) | Худал үнэ (төгрөг) | |
|----------|--|-----------------------------------|----------|------------|-----------------------|--|--|--------------------|---------------------------------|
| 1 | Суудлын автомашин, Сүзүки Витара, 00-34 ДАХ, JSAHTX92V00206265 | 2004/2005 | 140,402 | 1 | 37,170,000.00 | 37,170,000.00 | - | 1,500,000.00 | |
| Нийт дүн | | | | | | 37,170,000.00 | 37,170,000.00 | - | 1,500,000.00 |
| | | | | | | (гучин долоон сая нэг зуун далан мянган) | (гучин долоон сая нэг зуун далан мянган) | | (нэг сая нэг зуун далан мянган) |